

АРЬСНЫ ӨВЧИН СУДЛАЛЫН ҮНДЭСНИЙ ТӨВИЙН 2025 ОНЫ ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАНД ХИЙСЭН ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭ ҮНЭЛГЭЭ

2025 оны байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 7 зорилго 8 зорилтын хүрээнд нийт 40 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөсөн байна. 2025 оны 12 дугаар сарын 23-ны өдөр тус төлөвлөгөөний тайлангийн хэрэгжилтэнд хяналт шинжилгээг үнэлгээг хийв. Үүнд:

1. Эмнэлгийн тусламж, үйлчилгээний тасралтгүй байдлыг хангах, хүртээмжийг нэмэгдүүлэх зорилгын хүрээнд 12 ажил төлөвлөсөн байна. Үүнээс Эрүүл мэндийн сайдаас тусгайлан үүрэг болгосон арга хэмжээний зорилтын дагуу 7 ажлыг хэрэгжүүлж гүйцэтгэл 85.7 хувь, арьс харшлын өвчний тусламж, үйлчилгээг чанартай үзүүлэх, нэр төрөл, хүртээмжийг нэмэгдүүлэх зорилтын дагуу 5 ажлыг хэрэгжүүлж гүйцэтгэл 100 хувь байна. Тус зорилтын хүрээнд хэрэгжүүлсэн нийт ажлын гүйцэтгэл 92.85 хувь байна
2. Иргэдэд нийгмийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээг хүргэх зорилгын хүрээнд 2 ажил төлөвлөж хэрэгжүүлсэн. Арьс харшлын өвчнөөс урьдчилан сэргийлэх, эрсдэлт хүчин зүйлсийг бууруулах чиглэлээр олон нийтэд эрүүл мэндийн боловсрол олгох ажлын хэрэгжилт 100 хувь байна.
3. Эмнэлгийн тусламж, үйлчилгээний чанар, аюулгүй байдлыг хангаж эрсдэлээс сэргийлэх зорилгын хүрээнд 9 ажил төлөвлөсөн. Үүнээс эмнэлгийн тусламж, үйлчилгээний чанарын удирдлагын тогтолцоо, арга хэрэгслийг сайжруулан, тасралтгүй байдлыг хангах зорилтын дагуу хийсэн 7 ажлын гүйцэтгэл 100 хувь, эмнэлгийн халдвар, хамгаалал, аюулгүй байдлыг хангах чиглэлээр хэрэгжүүлсэн 2 ажлын гүйцэтгэл 100 хувь байна. Тус зорилтын хүрээнд хэрэгжүүлсэн нийт ажлын гүйцэтгэл 100 хувь байна.
4. Тасралтгүй суралцагч байгууллага байж, хүний нөөцийг хөгжүүлэх зорилгын хүрээнд 8 ажил төлөвлөсөн байна. Үүнээс арьс харшил, эмчилгээний гоо заслын чиглэлээр чадварлаг мэргэшсэн хүний нөөцөөр хангах зорилтын дагуу 3 ажил хэрэгжүүлж гүйцэтгэл 100 хувь, эмч, эмнэлгийн ажилчдын нийгмийн баталгааг сайжруулж, дэмжлэгт удирдлагаар хангаж ажиллах чиглэлээр 3 ажлын хэрэгжилт 93.3 хувь, эмч, эмнэлгийн ажилчдын ёс зүй, сахилга хариуцлагыг сайжруулах зорилтын дагуу хийсэн 2 ажлын хэрэгжилт 100 хувь

байна. Тус зорилтын хүрээнд хэрэгжүүлсэн нийт ажлын гүйцэтгэл 97.7 хувь байна.

5. Дэвшилтэт шинэ техник, технологийг нэвтрүүлэх зорилтын хүрээнд 3 ажлыг төлөвлөж эмнэлгийн тусламж, үйлчилгээнд шаардлагатай тоног төхөөрөмжөөр хангах төлөвлөгөөний хэрэгжилт 95.5 хувь байна.
6. Үйлчлүүлэгчдэд ээлтэй, аюулгүй орчныг бүрдүүлэх зорилтын хүрээнд төлөвлөсөн 3 ажлын хэрэгжилт 100 хувь байна.
7. Хагас бие даасан засаглалыг хөгжүүлэх, санхүүгийн ил тод байдлыг хангаж ажиллах зорилтын хүрээнд төлөвлөсөн 3 ажлын хэрэгжилт 100 хувь байна.

ДҮГНЭЛТ

2025 оны байгууллагын гүйцэтгэлийн жилийн төлөвлөгөөнд 7 зорилго 8 зорилтын хүрээнд төлөвлөсөн 40 арга хэмжээний хэрэгжилт 98 хувь байна.

ЦААШИД АВАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ САНАЛ

1. Эмнэлгийн тусламж, үйлчилгээний тасралтгүй байдлыг хангах, хүртээмжийг нэмэгдүүлэх зорилгын хүрээнд Эрүүл мэндийн сайдаас тусгайлан үүрэг болгосон арга хэмжээг бүрэн хэрэгжүүлэхэд анхаарах, шинэ техник технологи нэвтрүүлэх ажлыг эрчимжүүлэх;
2. Арьс харшил, эмчилгээний гоо заслын чиглэлээр чадварлаг мэргэшсэн хүний нөөцөөр хангах зорилтын хүрээнд доктор магистрын тоог нэмэгдүүлэхэд байгууллагаас дэмжлэг үзүүлэх;
3. Эмч, эмнэлгийн ажилчдын нийгмийн баталгааг сайжруулж, дэмжлэгт удирдлагаар хангаж ажиллах зорилтын хүрээнд ажилчдыг орон сууцтай болгох орон сууцны зээлд хамруулахад дэмжлэг үзүүлж ажиллах;

ДХН-ИЙН ДАРГА

Т.БАЯРМАА